

АГУУЛГА

1.1. Зорилго.....	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх товч танилцуулга	3
1.3. Төслийн байршил	3
1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшил болон хайгуулын ажлын талаарх товч түүх	3
1.5 Төслийн хүчин чадал, бүтэц, бүрэлдэхүүн	5
БҮЛЭГ 2. ОРДЫН НӨӨЦ	6
2.1. Ордын геологийн тогтоц	6
2.2. Ордын гидрогеологийн нөхцөл	6
2.3. Нөөцийн тооцооны үр дүн	6
2.4. Төслийн хүчин чадал, бүтэц, бүрэлдэхүүн	6
БҮЛЭГ 3. ИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ	7
3.1. “Цагаан чулуут-1” алтны үндсэн ордын 2026 оны олборлолт	7
3.2. Ашиглалтын систем	7
3.3. Ордын нөөц.....	7
3.4. Уурхайн олборлолтын хүчин чадал.....	8
3.5. Ажиллах горим.....	8
3.6. Календарьчилсан төлөвлөгөө.....	8
БҮЛЭГ 4. НУРУУЛДАН УУСГАХ ҮЙЛДВЭР.....	9
4.1. Үйлдвэрийн аюулгүй ажиллагаа	10
4.2. Химийн хорт болон аюултай бодисыг хадгалахад тавих шаардлага	10
4.3. Дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж хэвшүүлнэ:.....	11
БҮЛЭГ 5. ДЭД БҮТЭЦ.....	12
5.1. Барилга байгууламж	12
5.1.1. Нуруулдан уусгах үйлдвэрийн барилга	12
5.1.2. Уурын зуух	12
5.1.3. Уурхайн хотхон	12
5.1.4. Тэсрэх материалын агуулах.....	12
5.1.5. Засвар механикийн хэсэг	13
5.2. Цахилгаан хангамж	13
5.2.1. Бүс нутгийн цахилгаан хангамжийн эх үүсвэр	13
5.3. Уурхайн усны хэрэглээ	13
БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
БҮЛЭГ 7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ 8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨР	18
БҮЛЭГ 9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
БҮЛЭГ 10. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
БҮЛЭГ 11. ХИМИЙН БОЛОН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
БҮЛЭГ 12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 13. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
БҮЛЭГ 14. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	25
БҮЛЭГ 15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	30

БҮЛЭГ 16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сум багын иргэдэд тайлагнах ажлын хуваарь	31
БҮЛЭГ 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв.....	32

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Талбайн солбицол	5
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 3. Дүйцүүлэн хамгаалах ажил	18
Хүснэгт 4. Химийн хорт болон аюултай бодис хэрэглэх, хадгалах үеийн төл	19
Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
Хүснэгт 8. мониторингийн цэгүүдийн координат	29
Хүснэгт 9. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	30
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	31
Хүснэгт 11. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	32

Зургийн жагсаалт

Зураг 1. талбайн байршлын тойм зураг	4
Зураг 2. мониторингийн цэгүүдийн байршил	28

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Зорилго

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших “Цагаан чулуут-1” алтны үндсэн ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх товч танилцуулга

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эс Жи гоулд майнинг” ХХК нь Монгол улсын аж ахуйн нэгжийн бүртгэлд гадаад худалдаа чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

1.3. Төслийн байршил

“Цагаан чулуут-1” алтны үндсэн орд нь Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших ба 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн М-49-95 тоот хавтгайд орших бөгөөд 457.3 гектар талбайг хамарна.


1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшил болон хайгуулын ажлын талаарх товч түүх

Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн Дорнод аймгийн Баяндун сумын нутагт “Цагаан чулуут-1” нэртэй газарт орших 457.29 гектар талбайг хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч “Эс Жи групп” ХХК-д тусгай зөвшөөрлийг 2043 оны 01 дугаар сарын 25-ны өдрийг дуустал олгосон. Тус ашиглалтын тусгай зөвшөөрлийг ГУУКХ-ийн даргын 2010 оны 05-р сарын 27-ны өдрийн 608 тоот шийдвэрээр Эс Жи майнинг эрдэнэс ХХК-д, кадастрын хэлтсийн даргын 2015 оны 06-р сарын 12-ны өдрийн 173 тоот шийдвэрээр Эс Жи Гойлд Майнинг ХХК-д тус тус шилжүүлсэн.

Эс жи гоулд майнинг ХХК нь тухайн тусгай зөвшөөрөлтэй талбайд 2012 онуудад хайгуулын ажлыг гүйцэтгэж, алтны үндсэн ордын бодитой болон боломжтой (В+С) нөөцийг тогтоож, хайгуулын ажилд 1440506249.0 төгрөг зарцуулсан.

Цагаан чулуут-1 нэртэй талбайд хайгуулын 7 шугамд 250м-ийн дундаж гүнтэй 26 цооног буюу 7209.7 т/м өрөмдлөгийн ажил гүйцэтгэсэн.

Цагаан чулуут-1 алтны үндсэн ордын нөөц 2013 оны 07-р сарын 02-ны байдлаар бодитой (В) зэргээр 16468.1 мян.тн хүдэрт 0.5 гр/тн дундаж агуулгатай 8301.6 кг алт, боломжтой (С) зэргээр 5511.4 мян.тн хүдэрт 0.46 гр/тн дундаж агуулгатай 2544.6 кг алт, бодитой болон боломжтой (В+С) зэргийн нөөцийг 21979.5 мян.тн хүдэрт 0.48 гр/тн дундаж агуулгатай 10846.2 кг алтны нөөцийг зохиогчийн хувилбараар хүлээн авсан.



Зураг 1. талбайн байршлын тойм зураг

Хүснэгт 1. Талбайн солбицол

#	Уртраг	Өргөрөг
1	113° 26' 2.1"	49° 27' 41.95"
2	113° 26' 1.96"	49° 30' 2.01"
3	113° 25' 12.01"	49° 30' 2.01"
4	113° 25' 12.11"	49° 29' 42.95"
5	113° 24' 55.62"	49° 29' 42.95"
6	113° 24' 54.66"	49° 29' 31.7"
7	113° 25' 3.1"	49° 29' 31.52"
8	113° 25' 2.03"	49° 29' 9.72"
9	113° 25' 11.46"	49° 29' 9.54"
10	113° 25' 10.15"	49° 28' 42.81"
11	113° 25' 12.17"	49° 28' 42.77"
12	113° 25' 10.83"	49° 28' 16.58"
13	113° 25' 12.81"	49° 28' 16.54"
14	113° 25' 12.03"	49° 28' 0.7"
15	113° 25' 17.49"	49° 28' 0.58"
16	113° 25' 17.11"	49° 27' 41.95"

1.5 Төслийн хүчин чадал, бүтэц, бүрэлдэхүүн

Уурхайн хүчин чадал: Ил уурхайн хүчин чадал жилд 1,500.0 мян.тн хүдэр олборлон баяжуулахаар ТЭЗҮ боловсруулсан байна.

Ашиглалтын хугацаа: Ил уурхайн хүрээ хязгаарын оновчлолоор уурхайн үйлдвэрлэлийн нөөцөд 6,214.9 мян.тн хүдэр багтаж байгаа ба ТЭЗҮ-д жилийн 1,500.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар 5 жилийн хугацаанд олборлохоор тусгажээ. Цаашид ашиглалтын үеийн хайгуул хийж, нөөцийн зэрэглэл боломжтой (С) зэрэглэлээс бодитой (В) зэрэглэлийн нөөц рүү шилжсэн тохиолдолд ордын нийт нөөцийг 16 хүртэлх жилийн хугацаанд олборлох боломжтой болох юм.

“Цагаан чулуут-1” алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах төслийг дараах хэсгүүдэд ангилж болох юм. Үүнд:

- ✓ Ил уурхайн олборлолт
- ✓ Нуруулдан уусгах үйлдвэр
- ✓ Ажилчдын хотхон

Төслийн хэмжээнд нийт 324 ажлын байр бий болох ба нэг ээлжинд 161 хүн ажиллана гэж тооцсон.

БҮЛЭГ 2. ОРДЫН НӨӨЦ

2.1. Ордын геологийн тогтоц

Газрын гадаргын хувьд Монгол-Дагуурын зүүн хойд хэсгийн нам уулсын бүс, Дорнодын өндөрлөг талын баруун хойд хэсэгт хамаарна. Жижиг толгодорхог болон хээр талын хосолсон рельефтэй. Судалгааны талбайн рельефийн өндөр нь далайн түвшнээс дээш 1112-1199 м.

2.2. Ордын гидрогеологийн нөхцөл

Цагаанчулуут алтны үндсэн ордын талбайд 2012 онд хайгуулаар өрөмдсөн цооногуудад гидрогеологийн ажиглалт хийх мөн цооногуудад усны түвшингийн хэмжилт хийх, хайгуулын өрөмдлөгийн явцад газрын доорх усны илрэх гүнийг тогтоох ажиглалт явуулах болон өрөмдлөгийн дараа усны түвшин хэмжих ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Ордын талбайд өрөмдсөн цооногуудын чөмгийн сорьцуудыг судалж үзэхэд хайгуулын цооногуудад ус агуулах боломжтой ан цав, сулралын бүс багатай усажсан бүсийн зузаан бага 2,0-4,5м, байх ба ан цавшилтын тархалт багасаж 60 м-ээс нягт чулуулгийн үе үргэлжлэх бөгөөд цаашид цооногийн гүн ихсэх тутам ус агуулах боломжгүй харагдаж байдаг.

Талбайн хэмжээнд газрын доорх ус нь 26,6-42.0м-ийн гүнд газрын гадаргуугийн байдлаас хамааран байрлана. Усны урсцын чиглэл баруун урагш хойноос урд зүг чиглэсэн ерөнхийдөө газрын хэвгийн зүг чиглэлтэй. Газрын доорх ус нь агаарын хур тунадасны нэвчилтийн усаар тэжээгдэнэ.

Цагаанчулуутын ордын талбайд 2012 оны туршилт-шавхалтын ажлуудын үр дүнгээс харахад гидрогеологийн цооногийн усны ундарга 0,2 л/сек, түвшний бууралт 11,8м, байна. Талбайн хэмжээнд гидрогеологийн тооцооны үндсэн параметруудийн утгуудыг гидравликийн буюу графо-аналитикийн аргаар тооцсон байна. Тооцооны дүнгээс үзэхэд усажсан бүсийн шүүрлийн итгэлцүүр 0.6м/хон, мөн ундарга болон түвшин бууралтын хэмжээнээс үзэхэд усжилтын хэмжээ их бага байгаа нь илэрхий байна.

Дөрөвдөгчийн ангилагдаагүй сэвсгэр хурдас дахь уст давхарга нь тархалтын хувьд талбайг бүрэн бүрхэх боловч ус агуулах хэсэг нь аллюви-пролювийн хөндий, толгодын хоорондох хотгорт тархсан хайргатай бул чулуу, элсэнцэр, янз бүрийн ширхэгтэй элс, хайрга, дайрга, шавранцар, шавар бүхий давхаргаас бүрдэнэ. Зузаан нь 3-8 м. Энэ уст давхаргын газрын доорх ус нь ордын ашиглалтад ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Цагаанчулуут ордын гидрогеологийн судалгааны ажил болон ордын хүдэр, чулуулгийн физик-механикийн шинж чанарын судалгааны ажлын үр дүнгээс харахад 250 м хүртэл гүнд хүдрийн орд нь ил аргаар ашиглахад тааламжтай уул техникийн харьцангуй энгийн нөхцөлтэйг харуулж байна.

2.3. Нөөцийн тооцооны үр дүн

Цагаан Чулуутын алтны үндсэн ордод 2012 онд хийсэн хайгуулын ажлын үр дүнгээр Монголд улсад одоо мөрдөгдөж байгаа “Ашигт малтмалын нөөц баялгийн зэрэглэл”-д тавигдах шаардлагыг баримтлан геостатистикийн урвуу зайн хамаарлын арга (IDW) болон Кригингийн (МК) аргаар нөөцийн тооцоог хийж гүйцэтгэсэн.

2.4. Төслийн хүчин чадал, бүтэц, бүрэлдэхүүн

Уурхайн хүчин чадал: Ил уурхайн хүчин чадал жилд 1,500.0 мян.тн хүдэр олборлон баяжуулахаар ТЭЗҮ боловсруулсан байна.

Ашиглалтын хугацаа: Ил уурхайн хүрээ хязгаарын оновчлолоор уурхайн үйлдвэрлэлийн нөөцөд 6,214.9 мян.тн хүдэр багтаж байгаа ба ТЭЗҮ-д жилийн 1,500.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар 5 жилийн хугацаанд олборлохоор тусгажээ.

Цаашид ашиглалтын үеийн хайгуул хийж, нөөцийн зэрэглэл боломжтой (С) зэрэглэлээс бодитой (В) зэрэглэлийн нөөц рүү шилжсэн тохиолдолд ордын нийт нөөцийг 16 хүртэлх жилийн хугацаанд олборлох боломжтой болох юм.

БҮЛЭГ 3. ИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

3.1. “Цагаан чулуут-1” алтны үндсэн ордын 2026 оны олборлолт

Цагаан чулуут алтны үндсэн ордын нийт нөөцийг 18н жилийн хугацаанд олборлохоор тусгасан. Тус үйлдвэрлэлийн нөөцөд 21766697.5 тн хүдэрт 0.48 гр/тн дундаж агуулгатай 10538.1 кг алтны нөөц хамрагдаж байна. Үүнээс эхний 5н жилд 6214923.6 тн хүдэрт 0.65 гр/тн дундаж агуулгатай 4043.5 кг алтны нөөц хамрагдсан.

Үүнээс 2026 онд 1200.0 мян.тн хүдэрт 0.58 гр/тн дундаж агуулгатай 696.0 кг алт олборлож 1076.65 мян.м3 хөрс хуулахаар байна.

Ил уурхайн хөрс хуулалтын ажилд caterpillar 395F маркийн экскаватор, хүдэр олборлолтод caterpillar 350F маркийн экскаватор, ил уурхайн тээврийн тоног төхөөрөмжид MT-86 болон хово 371 маркийн автосамосвал, caterpillar 160 маркийн грейдер, caterpillar D9GC маркийн бульдозер, caterpillar 814F маркийн дугуйт бульдозер, caterpillar 950GC маркийн утгуурт ачигчууд тус тус ашиглана.

Өрөмдлөг тэсэлгээний ажлыг тусгай зөвшөөрөлтэй туслан гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлнэ. Цагаан чулуут-1 алтны үндсэн ордын уурхайн ажиллах горим нь хөдөлмөрийн тухай хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу уртын ээлжээр ажиллах ажилтны ажлын өдрийн үргэлжлэл 12 цагаас илүүгүй байх, уртын ээлжээр ажиллах ажилтны нэг ээлжид ажил үүрэг гүйцэтгэх хугацаа 14 хоног, амрах хугацаа 14 хоног байна гэсний дагуу ажиллана.

3.2. Ашиглалтын систем

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших Цагаан чулуут-1 нэртэй ордыг газрын гадаргаас хамааран 260-320 м хүртэл гүнд нөөцийг тооцсон байна. Хүдрийн биет нь дунджаар 403 метр урт, 380 метр өргөн ба агуулагч чулуулгийн хувьд диорит, гранодиорит, кварц диорит порфир зэрэг чулуулгуудаас тогтоно.

Ордын нөөц тогтоогдсон хэсгийн баруун жигүүр нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн хилээр хязгаарлагдсан учир уурхай нь баруун тийш тэлэлт хийх боломжгүй, гадаргуугийн өндөржилт нь 967-998 метрийн түвшний зөрүүний хооронд хэлбэлзэнэ.

Тухайн ордыг ашиглах ашиглалтын системийн хувьд уул-геологи болон уул-техникийн нөхцөлийг харгалзан үзэж ил аргаар авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр олборлоно.

3.3. Ордын нөөц

Ил уурхайн хүрээ хязгаарын оновчлолоор буюу эхний 5н жилд 6'214'923.6 тн хүдэрт 0.65 гр/тн дундаж агуулгатай 4043.5 кг алт олборлож, 15'811'458.5 тн хүдэрт 0.43 гр/тн дундаж агуулгатай 6746.0 кг алтны нөөц үлдэхээр харагдаж байна. Цаашид ашиглалтын үеийн хайгуул хийж боломжтой (С) нөөцийн зэрэглэлийг ахиулан бодитой (В) нөөцийн зэрэглэлд шилжүүлэх ажлууд хийгдэнэ.

Цаашид зэргэлдээ орших лицензтэйгээ гэрээ байгуулан ашиглалтын тусгай зөвшөөрлийн зүүн, ил уурхайн баруун талд үлдэж буй нөөцийг ил аргаар олборлолтын +832-р түвшин хүртэлх бүх нөөцийг бүрэн олборлоно. Улмаар +832-р түвшнээс дооших нөөцийг гүний уурхайн аргаар олборлоно.

3.4. Уурхайн олборлолтын хүчин чадал

Ил уурхайн хүчин чадлыг захиалагч компанийн ажлын даалгаврыг үндэслэн жилд 1,500.0 мян.тн хүдэр олборлон баяжуулахаар боловсруулсан.

3.5. Ажиллах горим

Уурхай нь бүтэн жил ажиллах ба үүнээс Монгол улсын “Хөдөлмөрийн хууль”-нд заасны дагуу жилд амрах баяр, ёслолын хоног, цаг агаарын хүндрэлээс шалтгаалан ил уурхайн ажиллагаа сул зогсож болзошгүй хугацааг тооцож нийт 312 хоног ажиллана.

3.6. Календарьчилсан төлөвлөгөө

Хүснэгт 2. Календарьчилсан төлөвлөлт

Үзүүлэлт	Хэмж их нэгж	1 дэх жил	2 дахь жил	3 дахь жил	4 дахь жил	5 дахь жил	Нийт
Уулын цул	м3	1,490,445.4	1,837,103.1	1,738,726.0	1,628,577.1	301,041.6	6,995,893.2
Хөрс	м3	1,076,652.3	1,319,861.7	1,281,267.2	1,111,335.7	123,481.7	4,912,598.7
Хүдэр	м3	413,793.1	517,241.4	517,241.4	517,241.4	177,559.9	2,143,077.1
Хүдэр	тн	1,200,000.0	1,500,000.0	1,500,000.0	1,500,000.0	514,923.6	6,214,923.6
Кх.х	м3/тн	0.90	0.88	0.85	0.74	0.24	0.79
Дундаж агуулга	гр/тн	0.58	0.61	0.66	0.73	0.67	0.65
Металл	кг	696.0	915.0	990.0	1,095.2	347.3	4,043.49

3.7. Уулын ажлын зохион байгуулалт

“Цагаан чулуут-1” алтны үндсэн ордыг ил аргаар, авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглах бөгөөд уурхайд өрөмдлөг тэсэлгээ, ухаж- ачих, тээвэрлэх, овоолох ба хураах гэсэн үндсэн процессууд явагдана. Мөн уурхайн ажлыг тасралтгүй хэвийн явуулахын тулд бусад туслах ажлууд үүний дотор өрөмдлөг тэсэлгээний ажлыг хамруулж байна. Ил уурхайн уулын ажлын эхэн үед хучаас хөрсийг экскаватор-автосомасвалын хослолоор олборлолтын талбайн гадна овоолго үүсгэнэ. Хөрс хуулалтын ажлыг түвшин бүрд хөндлөн орлоор хийж улмаар хүдрийг олборлон гадаад овоолгод хөрсийг хурааж ажиллах юм. Тэсэлгээ хийх доголын өндөр 6 м байх бөгөөд тус өрөмдөж тэсэлсэн доголыг экскаватор нь 3 метрээр 2 дэд догол болгон хувааж ухаж ачна.

3.8. Өрөмдлөг тэсэлгээний ажил

Өрмийн төхөөрөмжийн ажиллах талбайг засаж тэгшлэх, бэлтгэх ба туслах төхөөрөмжийг ажилд бэлтгэх, цахилгаан эрчим хүч, өрмийн багаж төхөөрөмж бусад материалаар хангах, өрөмдсөн цооногуудыг эвдрэлээс хамгаалах, бүртгэл, хэмжилт төхөөрөмжийн зөөвөр нүүдэл, засварын ажлын өөрчлөлт зэрэг олон туслах ажлууд байна.

Доголын талбайг өрөмдлөгт бэлтгэхдээ талбайд буй саад болох тоног төхөөрөмж бусад зүйлийг зайлуулах, тэгшлэх, зам засах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Өрөмдлөгийн ажлын төслөөр цооног бүрийн байршил, гүний хэмжээг тогтооно. Цооног янз бүрийн шалтгаанаар нурж гүн нь хорогдох зэрэг тохиолдолд дахиж өрөмдлөг хийж засварлана. Бусад ажиллагаанууд өрөмдлөгөөс шалтгаалан зогсохгүй байх, өрөмдлөгийн бүтээл өндөр, өртөг зардал хямд байх нь өрмийн төхөөрөмжийн ажлын зохион байгуулалтын зорилго юм. Бэлтгэл ажил ба өрөмдлөгийн блок дахь өрөмдөх ажиллагааг оновчтой хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын арга хэмжээг чиглүүлдэг. Өрмийн төхөөрөмжийг ажлын шинэ байршилд

шилжүүлэх, талбай засах, гэрэлтүүлгийн зориулалтаар цахилгаан хангамжийг бүрдүүлэх, цооногийн байрлалын тэмдэглэгээ хийх зэрэг нь бэлтгэл ажиллагаанд хамаарна.

БҮЛЭГ 4. НУРУУЛДАН УУСГАХ ҮЙЛДВЭР

Манай компани нь нуруулдан уусгах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг 2026 оны 2-р сард бүрэн дуусган улсын комисс ажиллуулан, химийн бодисын зөвшөөрлийг хөөцөлдөж бэлэн болгосны дараа буюу 5-р сараас эхлэн сард 125.0 мян.тн хүдэр нуруулдан уусгах хүчин чадалтайгаар ажиллаж 2026 онд нийт 1000.0 мян.тн хүдэр нуруулдан уусгах төлөвлөгөөтэй байна. Бид 2025 онд ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр оруулан батлуулж, нуруулдан уусгах үйлдвэрийн газрын гэрчилгээг аймаг орон нутгийн холбогдох байгууллагаар гаргуулж аван, нуруулдан уусгах үйлдвэрийн зураг төслийг барилгын хөгжлийн төвөөр оруулж батлуулсан. Мөн бид 2025 онд БНХАУ-н Xinhai компанитай холбогдон тоног төхөөрөмж худалдан авах, угсралтын ажлыг гүйцэтгэх талаар судалж гэрээ байгуулан баяжуулах үйлдвэрийн болон далангийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн, 2026 оны 2-р сарын эхээр үйлдвэрийн угсралтын ажлыг бүрэн дуусган үйлдвэр болон даланд тус сарын сүүлээр улсын комисс ажиллуулан, улсын комиссын өгсөн үүрэг даалгаврыг 14 хоногийн дотор засварлан сайжруулж хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн. Мөн 3-р сараас 4-р сарын хооронд химийн бодисын зөвшөөрлийг хөөцөлдөн, 5-р сараас эхлэн үйлдвэрийг жигдрүүлэн ажилуулж, орон нутгийн иргэдийг ажлын байраар ханган улс орон нутгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулан ажиллахаар манай компани төлөвлөж байна.

1. Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр баяжмалыг бөөнцөглөх фабрикийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм;

2. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам;

3. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам;

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр баяжуулах үйлдвэр, цехийн үйл ажиллагаа нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлох;

Баяжуулах үйлдвэр, цехийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан нөлөөллийг тухай бүр бүртгэн, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр гаргаж, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлэх

Баяжуулах үйлдвэрт хэрэглэх химийн хорт болон аюултай бодисыг худалдан авах, хадгалах, тээвэрлэх, ашиглах болон устгахад Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах болон устгах журмыг баримтлах;

Хаягдлын аж ахуйн зураг төслийг тооцоо судалгааны үндсэн дээр боловсруулах бөгөөд энэ нь техник, эдийн засгийн үндэслэлийн салшгүй хэсэг байх.

Хаягдлын аж ахуйн зураг төсөлд тусгагдсан цэвэр, бохир усны нуур, цөөрмийг үүсгэхдээ холбогдох дүрэм, журам, стандартыг баримтлах;

Хэрэв гадаадаас ажиллах хүч авч ажиллуулах бол Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч авах тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт заасныг мөрдөж ажиллах болон “Баяжуулах үйлдвэрт тавигдах бусад шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмыг баримтлан ажиллана.

4.1. Үйлдвэрийн аюулгүй ажиллагаа

- Хацарт бутлуур болон туузан конвейерийн дамжуулах хэсэгт аюулгүй ажиллагааны үүднээс хамгаалалтын хаалт хийх ба ажиллагсдын ажиллах үед гэнэтийн осол гарахаас сэргийлнэ.
- Ажлын тавцан, бункерийн хавхалга хаалт, ус зайлуулах суваг зэрэгт аюулгүйн хашлага, хөдөлгөөнт хаалт, анхааруулах хаяг тэмдэглэгээг хийж ажиллагсдын аюулгүй ажиллагааг хангаж өгнө.
- Технологийн гол тоног төхөөрөмжүүдийг ажиллуулах хангалттай талбайтай байлгах ба тоног төхөөрөмжийн 2 талд зохих өргөнтэй зай үлдээж, ажиллуулах, дамжин өнгөрөх, шалган засварлах хэсэгт аюулгүй байдлыг хангана.
- Тоног төхөөрөмжид гэмтэл саатал гарч шалган засварлах шаардлагатай тохиолдолд тухайн тоног төхөөрөмжийн шалган засварлах ажиллагааны журмыг нарийн баримталж гүйцэтгэх ба “цахилгаан тасарсан тэмдэглэгээ”-г чанд мөрдөнө. Мөн шалган засварлах ажилчид нь аюулгүйн хамгаалалтын хэрэгслээ бүрэн хэрэглэсэн, шаардлагатай ажлын хувцас, аюулгүй ажиллагааны малгай, тусгаарлагч бээлий, гутал зэргийг бэлтгэж хэрэглэнэ. Засвар үйлчилгээ хийж байх үед заавал анхааруулах тэмдэг, асааж унтраах, ажиллуулахыг хориглосон самбар хаалт байрлуулна. Засварлах ажиллагаа дууссаны дараа ажлын талбайг тухай бүрт нь цэвэрлэж, засварын ажиллагаа алдаагүй зөв хийгдсэн болохыг шалгасны дараа цахилгаан дамжуулж туршина.
- Цахилгаан тоног төхөөрөмжийн хэвийн нөхцөлд цэнэггүй байх металл гадаргуу болон бүхээгт хамгаалалтын газардуулга хийх ба гэнэтийн ослын тохиолдолд тог цохих, осол гарахаас урьдчилан сэргийлнэ.
- Цахилгаан хэрэглэхгүй тусгай цехийн цахилгааны хайрцаг, самбар, тоног төхөөрөмжүүдэд хаалт хамгаалалт хийж, цахилгаан цохихоос хамгаална
- Үйлдвэрлэлийн байр байгууламж нь гал эсэргүүцэх тоног төхөөрөмжүүд нь “Үйлдвэрийн газрын галын аюулаас урьдчилан сэргийлэх үлгэрчилсэн дүрэм”-ийг баримталсан байна.

Мөн **Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм**-ийг баримтлан ажиллана.

4.2. Химийн хорт болон аюултай бодисыг хадгалахад тавих шаардлага

1. Химийн бодисыг “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах” стандартын шаардлага хангасан зориулалтын агуулахад хадгална.
2. Химийн бодис хадгалах агуулахад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хүрээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ.
3. Химийн бодисыг орон сууцны, худалдаа үйлчилгээний газрын болон албан байгууллагын байшингийн зоорын давхарт хадгалахыг хориглоно.
4. Ажлын байран доторх бага хэмжээтэй химийн бодис хадгалах зөөврийн агуулахыг шат, аврах гарц, хонгилын эргэлтийн өнцөг, давчуу хонгил гэх мэт хүмүүсийн хөдөлгөөнд саад учруулах эрсдэлтэй газар болон албан тасалгаа, амрах өрөө, цайны газар, биеийн тамирын өрөө, эмнэлгийн тусламжийн өрөөний ойр байрлуулахыг хориглоно.
5. Химийн бодис экспортлох, импортлох, худалдах, ашиглах, үйлдвэрлэх зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь бодисыг хадгалахдаа дараах шаардлагыг биелүүлсэн байна:
6. Химийн бодисыг хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалбал хэт хөрснөөс талсжих; халснаас ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх; нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх, полимержих зэргээр бүтээгдэхүүний шинж чанар

өөрчлөгдөж, тэсэрч, дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах эрсдэлтэй тул хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгална.

4.3. Дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж хэвшүүлнэ:

- Техникийн хяналт, үйлчилгээг тогтмол хийж байх;
- Ажлын байранд хадгалах химийн бодисын хэмжээг аль болох багасгах;
- Барилга байгууламж дотор ашиглах химийн бодисын хэмжээг аль болох багасгах;
- Хадгалж байгаа химийн бодисыг үйлдвэрлэлийн процесс болон бусад үйл ажиллагаанаас тусгаарлах;
- Хамт хадгалж болохгүй бодисуудыг тусгаарлах;
- Химийн бодисын нөлөөлөлд өртөж болзошгүй ажиллагсдын тоог аль болох багасгах;
- Химийн бодис асгарч алдагдсан үед цэвэрлэх үйл ажиллагааг яаралтай авч хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх;
- Химийн бодисын хог хаягдлыг аюултай хог хаягдал устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлэх хүртэл түр хадгалах аюулгүй нөхцөлийг бүрдүүлсэн байх;
- Үйлдвэрлэлд ашиглаж байгаа тоног төхөөрөмж, материал нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх, жишээлбэл, оч үсэрдэггүй, шатамхай бус гэх мэт;
- Анхааруулах, сэрэмжлүүлэх тэмдэг тэмдэглэгээг ашиглах;
- Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр хангах (синтетик материал нь галд хайлж, түлэгдэлтийг нэмэгдүүлэх аюултайг анхаарах);
- Аюул ослын үед дохио өгөх дохиоллын систем, гал унтраах галын хор, багаж хэрэгслээр хангасан байх.

Үзүүлэлтүүд	Х.н	Төслийн хугацаа					6-10 дахь жил	10-16 дахь жил	Нийт
		1	2	3	4	5			
Олборлох хүдрийн хэмжээ	мян.тн	1,200.0	1,500.0	1,500.0	1,500.0	514.9	6,526.5	9,025.3	21,766.7
Хүдрийн агуулга	гр/тн	0.58	0.61	0.66	0.73	0.67	0.41	0.42	0.48
Хүдэр дэх алтны хэмжээ	кг	696.0	915.0	990.0	1095.0	345.0	2675.9	3790.6	10507.5
Нуруулдан уусгалтаар									
Нуруулдан уусгах хүдрийн хэмжээ	мян.тн	1,000.0	1,500.0	1,500.0	1,500.0	714.9	6,526.5	9,025.3	21,766.7
Алт авалт	%	73.9	73.9	73.9	73.9	73.9	73.9	73.9	73.9
Уусмалаас орж ирэх алт	кг	428.6	676.2	731.6	809.2	354.0	1977.5	2801.3	7778.3
Хаягдал									
Хаягдал дахь агуулга	гр/тн	0.15	0.16	0.17	0.19	0.17	0.11	0.11	0.126
Хаягдал дахь агуулга	кг	151.4	238.8	258.4	285.8	125.0	698.4	989.3	2,747.1
Хаягдлын гарц	%	100	100	100	100	100	100	100	100
Хаягдлын хэмжээ	мян.тн	1,000.0	1,500.0	1,500.0	1,500.0	714.9	6,526.5	9,025.3	6,214.9
Урсгалын хэмжээ	м³	386.1	579.2	579.2	579.2	276.0	2519.9	3484.7	2399.6
Шингээлтийн хэсэг									
Уусмалаас орж ирэх алт	кг	428.6	676.2	731.6	809.2	354.0	1977.5	2801.3	7778.3
Десорбци дахь алт авалт	%	98	98	98	98	98	98	98	98
Баян элюат руу шилжих алт	кг	420.1	662.7	717.0	793.0	346.9	1937.9	2745.2	7622.8
Электролиз									
Баян электролит дахь алт	кг	420.1	662.7	717.0	793.0	346.9	1937.9	2745.2	7622.8
Алдагдал	%	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Ган ноосон катодонд суух алт	кг	418.0	659.4	713.4	789.1	345.2	1928.2	2731.5	7584.7
Алт хайлах									
Ган ноосонд суух алт	кг	418.0	659.4	713.4	789.1	345.2	1928.2	2731.5	7584.7
Алдагдал	%	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Цэвэр алт	кг	415.9	656.1	709.8	785.1	343.4	1918.6	2717.9	7546.7

2026 онд хүдэр нуруулдан уусгах далан болон нуруулдан уусгах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлууд хийгдэх тул тус онд 1200.0 мян.тн хүдэр олборлож, 1000.0 мян.тн хүдэр нуруулдан уусгахаар төлөвлөж байна. Иймд 1000.0 мян.тн хүдэрт 0.58 гр/тн дундаж агуулгатай 580 кг алтыг нуруулдан уусгаж нуруулдан уусгалтаар авах алт авалт болон шингээлтийн хэсэг, электролиз, алт хайлах хэсгүүдийн хаягдлыг тооцоноор 415.9 кг алтыг гарган авч худалдан борлуулахаар байна.

БҮЛЭГ 5. ДЭД БҮТЭЦ

“Цагаан Чулуут-1” алтны үндсэн орд нь Улаанбаатар хотоос зүүн хойш 600 км, Дорнод аймгийн Чойбалсан хотоос баруун хойш 180 км, Дорнод аймгийн Баяндун сумаас хойш 30 км байрладаг.

Дорнод аймаг Монгол орны хамгийн зүүн зүгт оршдог. Хэрэглээний бүсчлэлээр зүүн бүст хамаарна. Умард талаараа ОХУ (Өвөр Байгалын хязгаар), зүүн талаараа БНХАУ (ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Хянган, Шилийн гол) гэх хоёр улстай хил залгана. Монгол улс дотроо Сүхбаатар, Хэнтий хоёр аймагтай хаяална. Тэгш тал газар зонхилно. Тус аймгийн нутагт байх Хөх нуурын хотгор (д.т.д. 560 метр) Монгол орны хамгийн нам дор газар гэгддэг.

Газрын гадаргын хувьд Монгол-Дагуурын зүүн хойд хэсгийн нам уулсын бүс, Дорнодын өндөрлөг талын баруун хойд хэсэгт хамаарна. Жижиг толгодорхог болон хээр талын хосолсон рельефтэй. Судалгааны талбайн рельефийн өндөр нь далайн түвшинээс дээш 1112-1199 м. Мал аж ахуй, газар тариалан голлон хөгжүүлсэн бөгөөд барилгын материал, хүнсний үйлдвэр хөгжүүлсэн. Аймгийн төв Чойбалсан хот нь төмөр замын цэг бөгөөд энд зүүн аймгуудад үйлчилдэг дамжлага бааз ажилладаг. Дорнод аймагт ОХУ руу гарах хилийн боомт Эрэнцав, Ямалах боомт Чулуунхороот суманд, Ульхан боомт Баян-Уул сумын нутагт, Хятад улс руу гарах Хавиргын боомт Чойбалсан суманд, Баянхошууны болон Өвдөгийн боомтууд Халхгол суманд тус тус бий. Давс, нүүрс (Адуун чулуу), холимог металл, уран, барилгын материал зэрэг ашигт малтмалтай.

5.1. Барилга байгууламж

5.1.1. Нуруулдан уусгах үйлдвэрийн барилга

Төсөл хэрэгжих хугацаанд үйлдвэрийн болон ахуйн барилга байгууламжуудыг барьж ашиглах бөгөөд эдгээр барилгуудыг зориулалтаас нь хамааруулан сэндвич болон контейнероор барьж байгуулахаар төлөвлөсөн.

Нуруулдан уусгах үйлдвэр нь энэ төрлийн үйлдвэрийн барилгад тавигдах стандартын шаардлагыг бүрэн хангасан байр байх бөгөөд тус барилгад үндсэн ба туслах тоног төхөөрөмжүүд байрлана. Нуруулдан уусгах үйлдвэрийн дулаан хангамжийн хувьд уурын зуух ашиглана.

5.1.2. Уурын зуух

Нуруулдан уусгах үйлдвэр, засвар механикийн цех, уурхайн оффис, лаборатори зэрэг барилга байгууламжуудын нийт талбай нь 9375.5 м² байна. Аж үйлдвэрийн барилгын дулаан алдагдлыг 150 Вт/м² гэж тооцвол нийт 1406325 Вт буюу 1406 кВт хүчин чадлатай уурын зуух хэрэг байна. Иймд 8000-10600 м² талбай халаах хүчин чадалтай бүхий КП1600 маркийн уурын зуух ашиглана. Тус уурын зуух нь үйлдвэрийн байрнаас 5 метрийн зайтай байна.

5.1.3. Уурхайн хотхон

Цагаан чулуут-1 ордын төсөл хэрэгжсэнээр 324 ажлын байр бий болох бөгөөд эдгээр хүмүүсийн ая тухтай, эрүүл орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Уурхайн хотхон нь ажилчдын байр, захиргаа удирдлагын байр, гал тогоо, халуун усны газар, уурын зуух, агуулах зэргээс бүрдэнэ.

5.1.4. Тэсрэх материалын агуулах

Тус агуулах нь 40 тн багтаамжтай 5 ш чингэлгийг галд тэсвэртэй материалаар доторлосон. Тэсрэх бодис хадгалах 40 тн багтаамжтай, 23.4 тн тэсрэх бодис хадгалах чингэлгийг галд тэсвэртэй материалаар доторлосон, дагалдах тэсэлгээний хэрэгслийг хадгалах агуулахуудаас бүрдэнэ. Үүнд:

- №01 дугаарын агуулахад савласан, олгойлсон анфо тэсрэх бодис D ангиллын материалуудыг хадгалахад зориулагдсан.
- №02 дугаарын агуулахад савласан, олгойлсон анфо тэсрэх бодис D ангиллын материалуудыг хадгалахад зориулагдсан.
- №03 дугаарын агуулахад савласан, олгойлсон анфо тэсрэх бодис D ангиллын материалуудыг хадгалахад зориулагдсан.
- №04 дугаарын агуулахад савласан, олгойлсон анфо тэсрэх бодис D ангиллын материалуудыг хадгалахад зориулагдсан.
- №05 дугаарын агуулахад савласан, олгойлсон анфо тэсрэх бодис B ангиллын материалуудыг хадгалахад зориулагдсан.

5.1.5. Засвар механикийн хэсэг

Цагаан чулуут-1 алтны үндсэн ордын машин механизмын удаан хугацааны найдвартай ажиллагааг хангахын тулд засвар, техник үйлчилгээний арга хэмжээг чанартай, тодорхой систем, төлөвлөгөөтэй авч хэрэгжүүлнэ.

Уурхайн засвар, техникийн үйлчилгээний хэсэг нь уул-тээврийн машин, тоног төхөөрөмж, бусад туслах тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор техникийн үйлчилгээний засварын ажилд шаардлагатай аливаа материал, сэлбэг хэрэгсэл, түлш, шатах тослох материал зэргийг хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, олгох зориулалттай байна.

5.2. Цахилгаан хангамж

5.2.1. Бүс нутгийн цахилгаан хангамжийн эх үүсвэр

Төслөөр эхний жилд нуруулдан уусгах үйлдвэрийн цахилгаан хангамжид Хятад улсад үйлдвэрлэсэн CTG 1375SD маркийн 1 мВт-ын хүчин чадалтай дизель станц, ил уурхайн цахилгаан хангамжид БНХАУ-д үйлдвэрлэсэн BC-20GF маркийн 20 кВт-ын чадалтай дизель цахилгаан үүсгүүр, засвар механикийн цех, агуулах, лабораторид БНХАУ-д үйлдвэрлэсэн BC-160CF маркийн 160 кВт-ын чадалтай дизель цахилгаан үүсгүүр, хотхоны хэрэглээнд БНХАУ-д үйлдвэрлэсэн BC-75GF маркийн 75 кВт-ын чадалтай дизель станцуудыг тус тус ажиллуулна. Уурхайн ашиглалтын 2 дахь жилд захиалагч компанийн техникийн даалгаврын дагуу Баяндун 35/10 кВ дэд станц дээр гаргалгаа хийж 32 км цахилгаан дамжуулах агаарын шугам татна.

5.3. Уурхайн усны хэрэглээ

“Цагаан чулуут-1” алтны үндсэн орд нь Монгол орны Улз голын сав газарт хамаарагдана. Уурхайн унд ахуйн хэрэглээний усыг өөрсдийн эзэмшлийн 1 л/сек ундаргатай гүний худгаас, технологийн усыг өөрсдийн эзэмшлийн 1 л/сек болон 4 л/сек ундаргатай 2 худгаас болон зэргэлдээ орших өөрсдийн эзэмшлийн MV-017164 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордын нуурын уснаас ашиглана.

БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

“Эс Жи гоулд майнинг” ХХК-ийн “Цагаан чулуут-1 алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах” төслийн БОННУ-ний тайлан боловсруулах ажлыг Монгол Улсын Байгаль хамгаалах тухай хууль болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд заасны дагуу болон Байгаль орчны үнэлгээний тайлан хийх аргачлалын дагуу хийж, 2026-2030 онд төслийн хэрэгжих хугацаанд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн технологи ажиллагааны онцлогтой нь уялдуулан олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлох арга, аргачлалын дагуу байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тус бүрд нь авч үзсэний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах бусад багц хууль, холбогдох журам, зааврын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар Монгол Улсын хуулиуд, шинээр гарч буй шаардлагатай уялдан байнга шинэчлэгдэж байх баримт бичиг төдийгүй төслийн хэрэгжилтийн үе шатанд байгаль хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөллийг тухай бүр нь бууруулж нөхөн сэргээх зорилтыг хангах үүрэгтэй юм.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4			5	6	9
Агаар орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр								
	Ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөс ялгарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд болон үйлдвэрлэгчийн холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлнэ.	Төсөлд хэрэгжүүлэхэд ашиглах бүх дотоод шаталтат хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, машин механизм	-		Дотоод үйл ажиллагааны зардалд	2026 он	<ul style="list-style-type: none"> - Монгол улсын стандарт - MNS 5013:2009 - MNS 5014:2009 - Агаарын тухай хууль, 9, 11, 23-р зүйл - MNS 4585:2016
		Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Уурхайн хэмжээнд	-		Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон	2026 он	
		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-		Дотоод үйл ажиллагааны зардалд	2026 он	
	Хатуу хучилтгүй зам дээрх тээврийн хөдөлгөөн, Бүтээгдэхүүн тээвэрлэж буй машинаас үүсч болох шороо тоосноос агаарт тоосжилт үүсэх	Усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг дулааны улиралд услах, чийглэх, замыг дагтаршуулах	Шороон замууд	км	2.5	5.0	2026 он	
		Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлаж, Хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, Тэмдэглэгээний арчилгаа	Шороон замууд	ш	20	5.0	2026 он	
Нийт						10.0		
Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
2	Нуруулдан уусгах талбайгаас шүүрсэн ус гадаргын болон газрын доорх усыг бохирдуулах	Хяналтын цооногуудад байнгын хяналт тавих	Хаягдлын далан	ш	5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт туссан	2026 он	<ul style="list-style-type: none"> Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008 БОНХС-ын 2013.05.16-ны А-156 тоот тушаал
	Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц	Ус ашиглах гүний худгууд болон цэвэр усны болон эргэлтийн усны системд усны тоолуур суурилуулах	Ус шахалтын цооногууд болон эргэлтийн усны систем	Ш	4	2.0	2026 он	

	хомсдох	Усны гэрээгээ байгуулан, ус ашиглах дүгнэлт гаргуулж, төлбөрөө төлөх		Дотоод төлөвлөлтөөр		2026 он		
Нийт					2.0			
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
3	Төслийн талбай болон орчны замын тохижилт муугаас үүдэн машин техник, хүний хөлөөр хөрсөн бүрхэвч доройтох	Газар эзэмших гэрээний дагуу төлбөрөө төлөх	Уурхайн хэмжээнд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд		2026 он	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Машины зогсоол шинээр бий болгож, талбайг цементлэх	Машины зогсоол	-	1.0		2026 он	
		ШТС-ын доод суурийг түлш, шатахуун асгарахаас сэргийлж суурийг цементлэх	ШТС-ын доод суурь хэсэгт		0.5		2026 он	
	Хаягдал тослох материал, химийн бодис хадгалах агуулахаас ачилт хийх явцад	Ачилт хийдэг зогсоолын талбайн орчинд асгаралтын эсрэг багаж, материалын иж бүрдлийг бэлэн байлгах	Хаягдал тос цуглуулах талбайнууд, химийн бодисын агуулах	ш	5	1.5	2026 он	
	санамсаргүй тохиолдлоор асгаралт үүсэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Аюултай хог хаягдлыг битүүмжилсэн саванд хадгалж, тэмдэг тэмдэглэгээ байршуулах;			Дотоод үйл ажиллагааны зардалд		2026 он	
Нийт					2.5			
Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг								
4	Төслийн үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвч доройтох	Мод үржүүлгийн талбай, хүлэмж байгуулах	Уурхайн талбайд	ш	10.0		2026 он	Байгалийн ургамлын тухай хууль 9-р зүйл
	Шувуу болон мэрэгч, хөхтөн амьтдыг цианидын уусмалд хордох	Шувуу үргээгч, шувууны бөмбөлөг, амьтан үргээгч зэрэг Төхөөрөмжүүдийг суурилуулах	Нуруулдан уусгах хүдрийн овоолго, баян уусмалын сан, эрчимт уусмалын сан	-	Дотоод үйл ажиллагааны зардалд		2026 он	MNS 6636 : 2016 MNS 6637 : 2016 Амьтны тухай хууль -Байгаль орчныг хамгаалах тухай MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
Нийт					-			
5	Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал					24.5		

БҮЛЭГ 7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаагаар 2026 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй. Энэ онд зөвхөн шимт хөрсний овоолгыг газар шорооны үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 стандартын дагуу 5 метрээс илүүгүй өндөр, 2 жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст өвслөг ургамал тарина гэсний дагуу жил тутамд шимт хөрсийг хамгаалах, хадгалах зардалд 7.5 сая.төг төсөвлөсөн.

БҮЛЭГ 8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨР

“ЭС Жи гоулд майнинг” ХХК нь 2026 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баяндун сумын засаг даргын 2026.04.10-ны өдрийн 01/139 тоот саналын дагуу хийж гүйцэтгэх.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 мод тарихаар төлөвлөв.

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах ажил

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Цар хүрээ	хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулах	Угтам уулын байгалийн нөөц газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах	Угтам уулын Байгалийн нөөц газар	Га	-	11300.0	2026 он
2	Тэр бум мод үндэсний хөдөлгөөний тухай	Баяндун сумын засаг даргын 2026.04.10-ны өдрийн 01/139 тоот саналын дагуу Сумаас зааж өгсөн талбайд 1000 ш мод тарина.	Сумаас зааж өгсөн талбайд	ш	1000	15000.0	2026 он
Нийт						26300.0	

БҮЛЭГ 9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

БҮЛЭГ 10. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой түүх соёлын өвийг хамгаалах ажил хийгдэхгүй болно.

БҮЛЭГ 11. ХИМИЙН БОЛОН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Химийн бодис, бүтээгдэхүүний хоруу чанарын ангиллын дагуу аюулыг тэмдэглэгээ, кодыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал зуучлалын сайд, эрүүл мэнд, спортын сайдын хамтарсан 2015 оны А356/396 тоот “Химийн хорт болон аюултай бодисын ангилал”-ын гарын авлагад заасан тодорхойлолт бүхий шинэ аргачлалын дагуу төслийн хүрээнд ашиглах зориулалттай нийт 18 нэр төрлийн химийн бодис хэрэглэнэ.

Хүснэгт 5. Химийн хорт болон аюултай бодис хэрэглэх, хадгалах үеийн төл

№	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, Сая. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
2	Химийн бодис болон химийн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, хэрэглэхэд болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх	Химийн аюултай болон хорт бодистой ажиллах ажилчдад өдөр бүрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллах	Үйлдвэрийн ажилчид	Дотоод үйл ажиллагааны зардалд орсон	Өдөр бүр
3		Агуулахад хадгалж буй химийн бодисын хор, аюулын шинж чанараас нь хамааруулан зохих анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тухай тэмдэглэгээг агуулахын гадна болон дотор байрлуулах,	Үйлдвэр, агуулахын талбай	2000.0	2026 он
4		Болзошгүй аюул, ослын үед ашиглах, хор аюулын лавлах мэдээлэлд заасан дараах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ашиглах дадлыг эзэмшүүлэх сургалт явуулах	Үйлдвэрийн ажилчид	2000.0	6 сард 1 удаа
5		Ажиллагсдад химийн бодис бүр дээр химийн бодистой ажиллах үед заавар зааварчилгааг өгөх, стандарт шаардлагыг хангасан ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл, багаж төхөөрөмжөөр хангах,	Үйлдвэрийн ажилчид	7000.0	2026 он
6		Химийн бодис хадгалах агуулахыг хадгалагдаж байгаа бодисын шинж чанараас хамааруулж МУ-ын Шадар сайд, БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 54/А/136/А215 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалдах, тээвэрлэх, ашиглах” устгах журам”-ын 3.5.2-д заасан хадгалалтын ангиллын хүснэгтийн дагуу ангилан хадгална.	Үйлдвэр, агуулахын талбай	Дотоод үйл ажиллагааны зардалд орсон	2026 он
6		Химийн бодис нь хайрцаг, сав, баглаа боодол, лац, ломбо бүрэн бүтэн, үйлдвэрлэгчийн хор аюулын мэдээллийн хуудас бүхий тоо хэмжээ, зэрэг	Үйлдвэр, агуулахын	-	Өдөр бүр

		дугаарын дагуу хүлээж авч, Агуулахын химийн бодисын орлого, зарлагын баримт, химийн бодисыг агуулахаас гаргах зөвшөөрөл зэрэг бичиг баримтуудын бүрдэлтийг заавал хангана.	талбайн ажилчид		
		Нийт		11000.0	

БҮЛЭГ 12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслоны хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог Хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг сумын ТҮК-тэй гэрээ байгуулан зөөвөрлөх	Баяндун сумын нэгдсэн хогийн цэгт хогоо нийлүүлэх	кг	Уурхайн дотоод зардалд орсон.			Хог хаягдлын тухай хууль
		Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна.	Ажилчдын байрны гадна болон баяжуулах үйлдвэрийн байрны дэргэд байршуулах	ш	-	6	1000.0	
		Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Ахуйн хог хаягдал хадгалах хэсэгт	Га	-	0.3	700.0	
		Ахуйн хог хаягдлаа цэвэрлэх зорилгоор уурхай орчмын талбайд их цэвэрлэгээ хийж орчин тойрноо цэвэрлэнэ.	Уурхайн талбай орчим	га	Уурхайн дотоод зардалд орсон.			
2	Үйлдвэрийн хог хаягдал	Уурхайд ашиглаж буй машинаас гарсан хаягдал тос, маслог зориулалтын цэгт хуримтлуулах, дугуй гэх мэтийг ангилах хадгалж, гэрээт газруудад тушаана.	Уурхайд ашиглагдаж буй машин болон бусад зүйлс	тоо	Уурхайн дотоод зардалд орсон			
3	Аюултай хог хаягдал	Аюултай хорт бодисыг гэрээт компани устгуулах	Химийн бодисын агуулах,	-	Уурхайн дотоод зардалд орсон			
		Химийн бодисын сав баглаа боодлыг зааврын дагуу саармагжуулан устгах болон хадгалах тодорхой цэгтэй байх	Үйлдвэрт ажиллах ашиглах сав баглаа боодлыг түр хадгалах		Уурхайн дотоод зардалд орсон			
Нийт						1700.0		

БҮЛЭГ 13. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ

Аянга цахилгаан: Дулааны улиралд тохиолдох бөгөөд цаг агаарын мэдээг тогтмол мэдээлэх хэрэгтэй. Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, ил задгай цахилгааны утас зэрэг аянга үүсэж болзошгүй зүйлүүдийг хамгаалах

Газар хөдлөлт: Газар хөдлөлтийн мужлалаар төсөл хэрэгжих газар нь 6 баллын бүсэд хамаарна. Иймээс барилга байгууламж барихдаа зураг төслийн дагуу эрсдэлийг нарийвчлан авч үзэх шаардлагатай. Мөн ашиглалтын явцад газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг боловсруулах. Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх.

Шороон шуурга: Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх Халдварт өвчин: Уурхайн ажилчдад хууль бус ан агнахгүй байх түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийн талаар сургалт явуулах, хамгаалалтын хэрэгслээр хангах (амны хаалт г.м), аймгийн эрүүл мэндийн төвтэй харилцаа холбоотой байж мэдээлэл авч байх

Гал түймэр: Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үд мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-н “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Аж ахуй нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна.

Авто тээврийн осол: Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах.

Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2	3	4	5	6	7	8
1.	Уурхайн эмнэлгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Анхны түргэн тусламжийн багаж, эмээр хангах	Уурхайн дээр	-	-	3000.0	2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
2	Анхны түргэн тусламжийн сургалтад хамруулах	Аливаа осол гэмтэлд өртсөн хүний биеийн байдлыг цаашид улам хүндрүүлэхгүй байх,	ажиглагсад			1000.0	2026 онд 1 удаа	
3	Ажлын байран дээрх осол эрсдэлээс сэргийлж хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангах	нэмж гэмтэл авахаас хамгаалах, биеийн чухал эрхтний үйл ажиллагааг сэргээх, хэвийн байдалд оруулахын тулд	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	Дотоод үйл ажиллагааны зардал		2026 он	
Нийт						4000.0		


БҮЛЭГ 14. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Эс Жи гоулд майнинг” ХХК-ийн “Цагаан чулуут-1” алтны үндсэн орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээний локаль мониторингийн систем байгуулах нь зүйтэй. Мониторингийн цэгийг зөв сонгож, хугацаа, давтамж зэргийг нь оновчтой сонгож өгөх нь чухал юм. Тус төслийн орчимд явуулбал зохих экологийн хяналтын мониторингийн ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, мониторингийн ажлын давтамж, хэмжилт судалгааны ажлыг хариуцах мэргэжилтэн, мониторингийн үзүүлэлт зэргийг доорх хүснэгтэд тусган оруулж өгөв.

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Байршил	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1		2	3	4	5	6	8
Агаар							
1.	Тоосжилтын нөлөөллийг хянах зорилгоор агаарт агуулагдах нарийн ширхэгт тоосонцрыг хэмжих	Уурхай, бутлуурын цех, Ажилчдын суурин, Ойролцоох малчин айл	5 болон 10-р сард	4 цэгт	-	1200.0	MNS4585: 2016
2.	Уурхай, орчмын гадаад орчны агаарын чанарын /NO ₂ , SO ₂ / хэмжилт хийх	Уурхай, Бутлуурын цех, Ажилчдын суурин, Ойролцоох малчин айл	5 болон 10-р сард	4 цэгт	-	600.0	MNS4585: 2016
Хөрс							
3.	Уурхайн шимт хөрсний овоолгуудын хөрсний шинж чанарын судалгаа хийх	Хөрсний мониторингийн цэгүүд	5 болон 10-р сард	3 цэгт		300.0	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
4.	Уурхай болон дэд бүтцийн барилга байгууламж орчмын хөрснөөс микро элементийн дээж авч шинжлүүлэх	Шатахуун түгээх станц, Химийн бодисын агуулах, Баяжуулах үйлдвэр, Уусмалын сан, Нуруулдан уусгах талбайн орчин, Ажилчдын суурин, Цэвэр хөрс, Засварын талбай орчим	5 болон 10-р сард	8 цэгт		800.0	
Ус							
5.	Булгийн уснуудад чанарын хяналт тавих	Төслийн талбай орчмын булгууд, нөхөн сэлбэлтийн усан сан	6 болон 10-р сард	4 цэгт	-	1500.0	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх
6.	Уусган баяжуулах талбай, уусмалын сангийн хяналтын цооногуудын усны түвшин болон эрдэсжилт, ЦДЧ, рН хэмжих	Хяналтын 5 цооног	улиралд 1 удаа	5 цэгт	-	2400.0	цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005,
7.	Ажилчдын унд ахуйн усанд чанарын хяналт тавих	Унд ахуйн ус	улиралд 1 удаа	1 цэгт	-	1200.0	
Ургамал, амьтан							

8.	Уурхай орчим болон дэд бүтцийн барилга байгууламж орчмын ургамлан бүрхэвчийн судалгаа хийх	Төслийн талбай орчим	Жилд нэг удаа	5 цэгт		1500.0	
9.	Жижиг хөхтөн амьтны зүйлийн олон янз байдлын төлөв байдлын болон нүүдлийн шувуудын ажиглалт судалгаа	Төслийн талбай орчим	Жилд нэг удаа	Төслийн талбайд		3000.0	
10	Нийт					12500.0	



Зураг 2. мониторингийн цэгүүдийн байршил

Д.Д	Цэгийн нэр	X*	Y*
Агаарын мониторингийн цэгүүд			
1	Уурхай	113° 25' 23.7"" E	49° 29' 35.97"" N
2	Бутлуурын цех	113° 25' 25.92"" E	49° 29' 23.32"" N
3	Уурхайн оффис	113° 25' 33.24"" E	49° 28' 53.89"" N
4	Ажилчдын суурин	113° 25' 32.39"" E	49° 27' 43.08"" N
5	Айлын өвөлжөө	113° 24' 16.41"" E	49° 27' 42.0"" N
6	Айлын өвөлжөө	113° 22' 44.95"" E	49° 28' 38.28"" N
Усны бохирдлын мониторингийн цэгүүдийн байршил			
1	Булаг	113° 26' 17.96"" E	49° 28' 23.78"" N
2	Булаг	113° 28' 0.9"" E	49° 27' 2.6"" N
3	Гүн өндөр булаг	113° 22' 24.65"" E	49° 28' 23.62"" N
4	Хяналтын цооног	113° 25' 10.66"" E	49° 28' 47.5"" N
5	Хяналтын цооног	113° 25' 12.27"" E	49° 28' 50.15"" N
6	Хяналтын цооног	113° 25' 11.7"" E	49° 28' 53.14"" N
7	Хяналтын цооног	113° 25' 12.16"" E	49° 29' 2.39"" N
8	Хяналтын цооног	113° 25' 12.61"" E	49° 29' 11.37"" N
9	Унд ахуй	113° 25' 33.31"" E	49° 27' 43.84"" N
10	Нөхөн сэлбэлт	113° 25' 37.99"" E	49° 29' 1.7"" N
Хөрсний мониторингийн цэгүүдийн байршил			
1	Шимт хөрс	113° 25' 6.55"" E	49° 29' 30.68"" N
2	Шимт хөрс	113° 25' 14.82"" E	49° 29' 57.24"" N
3	Шатахуун түгээх станц	113° 25' 23.75"" E	49° 29' 29.23"" N
4	Химийн бодисын агуулах	113° 25' 39.54"" E	49° 28' 53.81"" N
5	Баяжуулах үйлдвэр	113° 25' 33.19"" E	49° 28' 50.87"" N
6	Уусмалын сан	113° 25' 17.04"" E	49° 28' 44.23"" N
7	Нуруулдан уусгах талбайн орчин	113° 25' 24.8"" E	49° 28' 50.78"" N
8	Ажилчдын суурин	113° 25' 33.24"" E	49° 27' 42.45"" N
9	Цэвэр хөрс	113° 26' 40.82"" E	49° 28' 4.49"" N
10	Засварын талбай	113° 25' 37.41" E	49° 28' 55.44" N

Хүснэгт 9. Мониторингийн цэгүүдийн координат

БҮЛЭГ 15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана.

Хүснэгт 10. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Үерийн уснаас зайлс хийх	Уурхайн үер уснаас хамгаалах суваг шуудуу татах	Төслийн талбай	2000.0	2026 он
Төслийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хаалттай байлгаснаар олон нийтийг төөрөгдүүлэх, сөрөг сэтгэгдэл төрүүлэхээс зайлс хийх	Төслийн үйл ажиллагаа, байгаль хамгаалах чиглэлээр хийгдэж буй ажлуудыг олон нийтэд сурталчлах Сум орон нутгийн иргэд, малчидтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллах, малын мах, сүү, цагаан идээ зэрэг бүтээгдэхүүнийг худалдан авч хамтран ажиллах	Баяндун сумын иргэд, Сонирхогч талууд, Багын иргэд	Орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд жил бүр төлөвлөн хэрэгжүүлэх	
Байнгын хүнд, хортой нөхцөлд Ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажиллагсад	5000.0	2026 он
Нийт			7000.0	

БҮЛЭГ 16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сум багын иргэдэд тайлагнах ажлын хуваарь

Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.		10-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.	-
2		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.		11 сарын 1-нд багтаан			-
	Нийт	Дотоод үйл ажиллагааны зардалд орсон.					

БҮЛЭГ 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв
Хүснэгт 12. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	24.5
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	7.5
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	11.3
4	Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих	15.0
5	Химийн болон аюултай бодисын менежмент	11.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1.7
7	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
8	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	4.0
9	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	12.5
11	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	10.0
	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	97.5

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нөхөн сэргээх арга хэмжээнд нийт 97.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Үүний 50 хувь болох 48.75 сая төгрөг байна. Бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.